

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ /2019-2021 ОН/**

АУДИТЫН КОД: АГГ-2022/22-ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас
www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....
Аудитын зорилт, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүйн талаарх
мэдээлэл.....

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийх шаардлагатай байна.

1.2 Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүй, эрх бүхий байгууллага нь хяналгүй шууд баталсан байна.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтод түвшинд хүрээгүй байна.

2.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтод түвшнийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны зардлыг хяналтгүй зарцуулжээ.

БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Хөндлөнгийн хяналтууд тодорхой хэмжээнд хийгдсэн байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.3 Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах ажил хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
АТГ	Авлигатай тэмцэх газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АТӨЯХАТ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтыг хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Компанийн засаглалын бодлого үр дүнтэй эсэх
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, ЗГ-аас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн ТУЗ-өөс гаргасан шийдвэр, бусад хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, холбогдох төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

ҮАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн түүврээр сонгон үзэж буй 80 хуулийн этгээдийн орон нутаг дахь салбар байгууллагуудын засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэлт өгсөн.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар нь ЗАВХАН-АЗЗА ТӨХК, Амь-Ус трейд ОНӨААН, “Тосонцэнгэл сумын нисэх” буудал ТӨҮГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаанд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Хууль

- МУ-ын үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг /1992/
- МУИХ-ын тухай хууль /2016,2020/
- МУЗГ-ын тухай хууль 1993
- МУ-ын яамны эрх зүйн байдлын тухай хууль /2004/
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 1996
- Компанийн тухай хууль /2011/

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль 2005
- Авлигын эсрэг хууль /2006
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /2015/
- Төсвийн тухай хууль /2011/
- МУ-ын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай 2017-2020 оны хууль
- МУ-ын төсвийн тухай хууль 2017-2021
- Төрийн албаны тухай хууль /2017/
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /2003/
- МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2016. 2021/
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль /2010/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Татварын ерөнхий хууль /2019/

УИХ-ын тогтоол

- 2016 оны 19 дүгээр тогтоол “МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- 2016 оны 45 дугаар тогтоол “МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- 2020 оны 24 дүгээр тогтоол “МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- 2020 оны 23 дугаар тогтоол “МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоол “санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”
- УИХ-аас гарсан холбогдох бусад тогтоол

ЗГ-ын тогтоол

- 2019 оны 290 дүгээр тогтоол “МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг тодотгон батлах тухай
- 2018 оны 140 дүгээр тогтоол “ МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- 2016 оны 121 дүгээр тогтоол “МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- 2011 оны 69 дүгээр тогтоол Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
- 2016 оны 80 дугаар тогтоол “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам
- 2016 оны 91 дүгээр тогтоол “ Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр
- 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Засгийн газраас гаргасан холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд

Бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд

- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”
- Байгууллагын засаглалын ОУ-ын удирдамж ISO 37000 стандарт

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Компанийн засаглалын зарчмууд”
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд
- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 тушаалаар баталсан “татвар төлөгчийг бүртгэх журам”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “ Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3910, УДИР 3920, МУ-ын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглаж гүйцэтгэлээ.

Аудитаар хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж ажиллаа.

Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Б.Дагвасүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Б.Жалбаа аудитыг гүйцэтгэлээ.

ҮАГ-аас ирсэн төлөвлөгөөнд үндэслэн орон нутгийн онцлогт тохируулан аудитын дэд төлөвлөгөөг боловсруулах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаанд гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор дарга тэргүүлэх аудитораар батлуулан, талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэж, холбогдох газруудад хүргүүлж, ҮАГ-т нэгтгүүллээ.

Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр эрчим хүч, зам тээвэр, уул уурхай, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, аялал жуулчлал, харилцаа холбоо, бусад гэж ангилж байна.

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар, нийтийн болоод хувийн холимог өмчөөр хуулийн этгээд байгуулж болох хуулийн зохицуулалттай бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар Завхан аймагт бүртгэлтэй ТӨҮГ, ТӨХК, ТӨХХК, ОНӨААТҮГ зэрэг 13 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийх шаардлагатай байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр үндэсний хөтөлбөр баталж, уг хөтөлбөртэй уялдуулан компанийн засаглалын кодексийг шинэчлэн, компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам батлагджээ.

“ЗАВХАН-АЗЗА” ТӨХК-нь Компанийн тухай хууль болон компанийн засаглалын кодексийн хүрээнд байгууллагын дүрмийг боловсруулж, удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлага гэсэн бүтэцтэй байхаар тусгасан байна. Хувьцаа эзэмшигчийн эрхийг ТӨБЗГ эзэмшиж байна. ТУЗ-ийг 9 гишүүнтэй байгуулсан бөгөөд үүний 3 нь хараат бус гишүүн байна. Мөн ТУЗ-ийн дэргэд аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороодыг байгуулжээ.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг судлан үзэхэд Зам тээврийн хөгжлийн яам болон, ТӨБЗГ-ын холбогдох алба хаагчид төрийн төлөөллийг хэрэгжүүлж байна. Энэ нь бодлогын түвшинд төрийн өмчит хувьцаат компанийн засаглалыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа хэдий ч тухайн байгууллагад хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг бий болгож байна гэж үзлээ.

Орон нутаг дахь төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахын тулд ТУЗ-д орон нутгийн төлөөллийг оруулж, уг төлөөллөөр дамжуулан хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй байна.

Мөн төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 3 “ аймаг нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана” гэсэн заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Аймгийн засаг даргын дэргэд орон нутгийн өмчийн алба ажиллаж байгаа бөгөөд энэхүү алба нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүлдэггүй байна. Төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс оролцох, хяналт тавих хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журамд хөрөнгийн биржийн 1, 2 дугаар ангилалд бүртгэлтэй компаниудад засаглалын үнэлгээ хийхээр тусгасан байна. Тус төрийн өмчит хуулийн этгээдэд нь хөрөнгийн биржид бүртгэлгүй учир компанийн засаглалын үнэлгээ хийгдээгүй байна.

ТӨБЗГ нь УИХ, ЗГ болон яамны шийдвэр, үүрэг чиглэлийг тухай бүр төрийн өмчийн компанид хүргүүлж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллахаас гадна хуульд заасан чиг үүргийн хүрээнд дараах шийдвэрүүдийг гарган ажилласан байна.

- ТӨХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах
- ТӨХК-ний үйл ажиллагаа эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний болон гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийг үнэлж дүгнэлт өгөх - Ингэхдээ хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэдэг байна.
- Үндсэн хөрөнгө бүртгэлд авах, бүртгэлээс хасах, балансаас баланс руу шилжүүлэх
- Ногдол ашгийн хэмжээг тогтоох, төвлөрүүлэх
- ТУЗ-д төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх, томилох
- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилох, чөлөөлөх- /ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн саналд үндэслэсэн/ зэрэг байна.

Зам тээврийн хөгжлийн яам, зам тээврийн хөгжлийн төв нь салбарын төрийн өмчит, өмчийн оролцоотой компанийн үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцож, удирдлагаар ханган ажиллаж байна. Тухайлбал: Алба хаагчдыг сургалтад хамруулах, судалгаа авах, шагнаж урамшуулах, зам арчлалт, ашиглалтын байдалд хяналт тавих, чиглэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, замын хөдөлгөөний эрчмийн тооллого хийх зэрэг байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд төрийн эрх бүхий байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна гэж үзлээ.

1.2 Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана”, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10.Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж тусгасан байна.

Эдгээр зорилтын хүрээнд ТӨБЗГ нь 2019 онд Монгол дахь Азийн сан, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-тай хамтран ажиллах гэрээг байгуулан, төлөвлөгөө боловсруулан ажилласан байна.

Харин төрийн өмчит компанийн захиралтай байгуулсан гэрээнд засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилттой холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээ тусгаадаагүй байна.

ТӨБЗГ-аас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх зорилгоор төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх

захирал, захиргааны нэгжийн дарга, дотоод аудит хариуцсан ажилтан нарт зориулсан компанийн засаглалын сертификат олгох сургалтыг 2019 онд зохион байгуулсан байна.

Мөн МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2020” өдөрлөгийг зохион байгуулсан байна. Үүнд төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга, нягтлан бодогч, худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтан, гүйцэтгэх захирал нарт зориулсан сургалтыг хийсэн байна.

Эдгээр сургалтын үр дүнд төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд дэвшил гарсан асуудал ажиглагдахгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтад төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хяналт тавьж, төрийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн системд хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэж хэвшсэн байна.

ТӨБЗГ нь хувьцаа эзэмшигчийн хувьд ТУЗ-д удирдамж чиглэл өгч ажилласан байна. үүнд:

- Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын сонгох
- Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах
- Орон тоо нэмж батлуулах
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах зэрэг чиглэлийг тогтмол өгч ажиллажээ.

ТУЗ нь ТӨБЗГ—аас өгсөн удирдамжид үндэслэн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

- ✓ Жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудит хийх хараат бус аудитыг сонгож, гэрээ байгуулах
- ✓ Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хэлэлцэн баталсан
- ✓ Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн тухай
- ✓ Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний биелэлт, газрын захиралтай байгуулсан контрактын биелэлтийн тухай
- ✓ ТУЗ-ийн даргыг сонгож батлах тухай
- ✓ ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнийг сонгох
- ✓ Компанийн дараа оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх зэрэг асуудлууд байна.

ТУЗ нь хамгийн чухал үүрэг болох компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, хяналт тавьж, удирдамж зөвлөмжөөр хангаж ажиллах үүргээ биелүүлээгүй, ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүй, эрх бүхий байгууллага нь хяналгүй шууд баталсан байна.

Төрийн өмчит компани нь эдийн засгийн зорилтод түвшнийг төлөвлөхдөө бодит тооцоо тооцоо судалгаанд үндэслэлгүй өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан тодорхой хэмжээний өсөлттэй боловсруулан ТУЗ-д хүргүүлдэг байна.

Эдийн засгийн зорилтод түвшний үзүүлэлтийн төсөл:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төлөвлөгөө		
	2019 он	2020 он	2021 он
Нийт орлого	999.0	869.2	1,395.7
Улсын чанартай авто зам засвар арчлалтын ажил	673.2	734.6	1,192.0
Орон нутгийн чанартай авто зам засвар арчлалтын ажил	325.8	134.6	203.7
Нийт зардал	983.2	855.2	1,362.4
Үүнээс Удирдлагын зардал	146.6	157.9	227.3
Татварын өмнөх ашиг/алдагдал/	15.8	14.0	33.3
Цэвэр ашиг /алдагдал/	14.3	12.6	30.0

ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын боловсруулж хүргүүлсэн төсөлд өөрчлөлт оруулалгүй шууд баталжээ

Төсвийн төлөвлөлтийг судлан үзэхэд тухайн жилд ямар ажил гүйцэтгэх нь тодорхой бус байна. Тухайлбал:

- Улс чанартай зам засварын арчлалтын хүрээнд төсөвлөсөн төсвийг хянахдаа ТУЗ нь ямар ажлыг хэдэн төгрөгөөр хийхээр төлөвлөсөн талаарх төсөвт үндэслэлгүй, гүйцэтгэх удирдлага нь тухайн жилд хийх зам засвар арчлалтын ажлын төсвийг ТУЗ-д танилцуулж, эдийн зорилтод үзүүлэлттэй уялдуулаагүй
- Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт болон бусад орлогоор хэдэн төгрөг оруулах, ямар эх үүсвэрээс орлого олох боломжтой талаар тодорхой төлөвлөгөөгүй, хийсвэрээр эдийн засгийн зорилтод түвшний үзүүлэлтэд тусгасан байна.

ТӨБЗГ нь ТУЗ-ийн хянасан төсөвт үндэслэн эдийн засгийн зорилтод түвшнийг баталсан байна. Энэхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний хүрээнд гүйцэтгэх удирдлага үйл ажиллагаа явуулахаар контракт байгуулан ажиллажээ.

2020 оны эдийн засгийн зорилтод түвшний үзүүлэлт өмнөх оноосоо буурсан нь тухайн ТӨХК-ний хариуцан ажиллаж байсан улсын чанартай авто замын зарим хэсгийг хувийн компанид хариуцуулах шийдвэр гарсантай холбоотой байна.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтод түвшинд хүрээгүй байна.

Завхан -АЗЗА ТӨХК улсын чанартай авто замын засвар арчлалтын санхүүжилт, орон нутгийн чанартай зам засварын ажлын санхүүжилт, гэнэтийн шинж чанартай онцгой ажлын болон бусад орлогыг төвлөрүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийг харьцуулбал:

д/д	Үзүүлэлт	2019		2020		2021	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Улсын чанартай авто замын санхүүжилт	673.2	665.8	734.6	1,107.3	1,192.0	965.3
2	Бусад орлого	325.8	14.2	134.6	220.7	203.7	0
	Нийт дүн	999.0	680.0	869.2	1,328.7	1,395.7	965.3

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн орлого бүрдүүлэлт зорилтод түвшний үзүүлэлтийг хангахгүй байгаа нь үндсэн үйл ажиллагаанаас гадна нэмэлт орлого олох боломж муу, орлогоо нэмэгдүүлэх тодорхой хэмжээний ажил зохион байгуулж ажиллаагүй, ТУЗ-өөс хэрэгжүүлж буй бодлого тодорхой бус зэрэг нь нөлөөлж байна гэж үзлээ.

2020 онд орлого бүрдүүлэлт зорилтод түвшний үзүүлэлтээс давж биелэхэд орон нутгийн зам засварын тендерийн ажилд оролцож 20.0 сая төгрөгийн , Сонгино суманд баригдах замын төлбөр авах цэг барих 200.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан болон Загастай давааны зам засварын ажлыг гүйцэтгэлтэй холбоотой түр замын ажил гүйцэтгэсэн зэрэг нөлөөлжээ.

ТӨХК нь НӨАТ, ААНОАТ, Үл хөдлөх хөрөнгийн татвар, АТӨЯХАТ, ХАОАТ, газрын төлбөр, НДШ зэрэг татвар, шимтгэл, төлбөр хураамжийг төвлөрүүлж байна.

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар:

д/д	Татварын нэр төрөл	2019	2020	2021	Нийт
1	Татварын байгууллагад төлсөн	88.5	96.9	67.2	252.6
2	ЭМНДШ	47.9	87.1	100.3	235.3
	ДҮН	136.4	184.0	167.5	487.9

Сүүлийн жилүүдэд улс орон нутгийн төсөвт нийт 487.9 сая төгрөгийн татвар төлж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 69.1 сая төгрөгийн татварын өртэй тайлагнажээ. Үүний 6.5 сая төгрөг нь ХАОАТ-ын , 62.6 сая төгрөг нь НӨАТ-ын өглөг байна.

Мөн 6.9 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ. Ногдол ашгийг цэвэр ашгийн 10 хувиар ногдуулан ТӨБЗГ-ын тогтоолоор баталгаажуулсан байна.

2.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтод түвшнийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Байгууллагын үйл ажиллагааны тайлан болон холбогдох материалтай танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж үр дүнг үнэлж дүгнэсэн үзүүлэлт байхгүй байна.

Тус байгууллагад эдийн засагчийн орон тоонд 2020-2021 онд албан хаагч авч ажиллуулсан хэдий ч байгууллагын үйл ажиллагаанд шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.

Аудитаар тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж эрдлийг үнэллээ.

- **Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлт:** Байгууллагад бараа материалын хомсдол үүсэх эрсдэл өндөр, үндсэн хөрөнгийн нөөц хангалтгүй, үр ашиггүй байгааг харуулсан дүгнэлт гарч байна. Харин авлага, өглөгийн хувьд эрсдэл багатай, компанийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого үр дүнтэй байна гэж үзлээ.

Тус компани нь үйл ажиллагаа явуулахад техник хэрэгслийн дутагдалтай байдал нь нь нөлөөлж байна гэж үзлээ. Тухайлбал тус компани нь үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг хувь иргэдээс өндөр үнээр түрээсэлж байна. Түрээсийн төлбөрт жилд дунджаар 123.6 төгрөгийг зарцуулжээ.

- **Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт:** Богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар харьцангуй эрсдэл багатай, харин бэлэн мөнгөний хомсдол үүсэх эрсдэл өндөр байна гэсэн үзүүлэлт гарч байна.

Замын аюулгүй, бэлэн байдалд хяналт тавих эрх бүхий төрийн байгууллагууд болох цагдаа, мэргэжлийн хяналтын газруудаас замын бэлэн байдалд хяналт хийж эвдрэл гэмтлийг засаг мэдэгдэл, албан даалгаврыг Завхан-АЗЗА ТӨХК-д тухай бүр хүргүүлэн ажилласан байна. Гэвч тухайн байгууллагад тус эвдрэл гэмтлийг засах мөнгөн хөрөнгийн нөөц хангалтгүй байна.

Энэхүү байдал нь хувь иргэдээс зээл авах нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж үзлээ.

- **Өр төлбөрийн харьцаа:** Нийт хөрөнгийн дүнд эзлэх урт хугацаат өр төлбөр бага буюу өрөө төлөх чадвар эрсдэл багатай байна. Тус байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүссэн богино хугацаат өр төлбөрийг 90.6 хувийг НӨАТ-ын өр эзэлж байна.

- **Ашигт ажиллагааны харьцаа:** Энэ нь тухайн компани хөрөнгийнхөө тусламжтайгаар ашигтай ажиллаж байгаа эсэхийг харуулдаг бөгөөд шинжилгээний үр дүнд ашигтай ажиллах боломж маш бага байгааг харуулж байна. Тухайлбал үйл ажиллагааны ахиуц ашиг 0.03-/-0.26/ байгаа нь үйл ажиллагааны зардалд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

“Завхан-АЗЗА” ТӨХК нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах зорилготой боловч уг зорилтоо хангаж чадахгүй байна. Энэ нь орон нутагт зам арчлалтын чиглэлээр хийгдэж буй ажлын тоо хэмжээ бага, техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн дутагдалтай байдал зэрэг нөлөөлж байна гэж үзлээ.

ТӨХК-ний үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримттай танилцахад их хэмжээний хэлцэл болон ашиг сонирхлын зөрчил бүхий гэрээ байгуулсан асуудал ажиглагдахгүй байна. Харин байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, гэрээт ажлыг цаг хугацаанд гүйцэтгэх зорилгоор 2020 онд 627.8 сая, 2021 онд 100.0 сая, нийт 728.8 төгрөгийг хувь иргэдээс зээлсэн байна. Энэхүү зээлийн төлбөрт 16.4 сая төгрөгийн хүү төлсөн нь үр ашиггүй зардал болсон байна.

2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үйл ажиллагааны зардлыг хяналтгүй зарцуулжээ.

ТӨХК-ний ТУЗ нь байгууллагын орон тоо бүтэц, удирдлагын зардал, үйлдвэрлэлийн зардал, хөрөнгө оруулалтын зардал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн саналд үндэслэн баталжээ.

Удирдлагын зардал: Сүүлийн 3 жилийн дунджаар тооцоход тус зардлын 75.5 хувь нь захиргаа аж ахуйн алба хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ТУЗ-ийн зардал байна. Завхан-АЗЗА ТӨХК-ний удирдлагыг 7 орон тоотой, ТУЗ-ийг 9 гишүүн, нарийн бичиг гэсэн бүтэцтэй баталжээ.

Удирдлагын зардлын төлөвлөлт:

Удирдлагын зардал	Төлөвлөгөө		
	2019	2020	2021
Цалин	81.0	82.5	119.8
ЭМНДШ-ажил олгогч	11.7	12.0	17.5
Албан томилолт	2.6	5.5	10.9
Шуудан холбооны зардал	2.0	3.1	3.8
Бичиг хэргийн зардал	1.2	2.2	3.2
Шатахуун-сэлбэг	11.7	11.7	12.4
Халаалтын зардал-цахилгаан халаалт	7.8	7.9	9.5
ҮХ-ийн элэгдэл	3.1	2.5	17.7
ТУЗ-н зардал	21.1	26.0	27.7
Сургалтын зардал, сурталчилгаа, нийгмийн асуудалд	3.5	3.6	3.7
Бусад зардал	0.9	0.9	1.1
ДҮН	146.6	157.9	227.3

Удирдлагын зардлын төлөвлөлтийг судлан үзэхэд цалин хөлсний зардлыг өмнөх оноос 45.2 хувь буюу 37.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь албан хаагчдад салбарт ажилласны нэмэгдэл, хоолны мөнгө олгох, үндсэн цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой бөгөөд томилолтын зардлыг 98.2 хувь буюу 5.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байна.

ТӨХК-ний удирдлагын бүрэлдэхүүний цалин хөлсийг хэрхэн тогтоож байгаа талаар судлан үзэхэд компанийн гүйцэтгэх удирдлага байгууллагын үйл ажиллагаа, ашигт байдалтай уялдуулан санал боловсруулан ТУЗ-өөр батлуулдаг байна. Тус ТӨХК-ний ашигт ажиллагаа хангалтгүй /алдагдалтай/ байхад цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь учир дутагдалтай байна гэж үзлээ.

Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтай алба хаагчид жилд 2-3 удаа томилолтоор УБ хот руу томилолтоор явдаг бөгөөд жилд дунджаар 3-4.5 сая төгрөгийн зардал гарчээ.

Удирдлагын зардлын зарцуулалтыг судлан үзэхэд үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан дараах зөрчлүүд илэрлээ.

- 2020 онд 1-3 орон тоо, 2021 онд 1 орон тоо илүү ажиллуулсан 16.5 сая
- Удирдлагын шуудан холбооны зардлаас гар утас /SAMSUNG S-9/ худалдан авсан бөгөөд утасны төлбөрийг давхардуулан шилжүүлсэн 1.8 сая
- Захиргаа аж ахуйн алба хаагчдад цалин, амралтын мөнгийг давхардуулан олгосон 7.1 сая
- Гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нарт 2018 оны ажлын үр дүнгийн урамшууллыг 2020 онд олгосон 5.2 сая
- Сангийн сайдын 2006 оны 292 тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын хүрээнд нягтлан бодогч нарт 2018, 2019 оны балансын урамшуулалд 5.4 сая төгрөг олгосон.
- Сайн дураараа ажлаасаа чөлөөлөгдөн, өөр байгууллагад шилжин ажиллаж буй алба хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал олгосон 1.8 сая
- ТУЗ-ийн шийдвэргүй гүйцэтгэх удирдлагад тусламж олгосон 5.6 сая төгрөгийн зөрчил байна.

Ийнхүү удирдлагын зардлыг зохистой хэмжээнд барьж ажиллаагүйгээс цалин хөлс болон ХАОАТ-ын өр үүссэн байна.

Үйл ажиллагааны зардал: Завхан-АЗЗА ТӨХК нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад техник, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдалтай холбоотой шаардлагатай техник хэрэгслийг түрээсэлж байна. Энэ нь хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл орон нутагт түрээслэх техник, тоног төхөөрөмжийн олдоц муу, түрээсийн төлбөр өндөр байдагтай холбоотой зарим нөхцөлд өөрийн байгууллагын ажилчин, албан хаагчидтай гэрээ байгуулан ажилласан байна.

Бүтээгдэхүүний өөрийн өртөг	Төлөвлөгөө		
	2019	2020	2021
Түүхий эд материал бусад материал	62.5	54.7	179.6
Түлш шатахуун	192.3	175.2	195.2
Сэлбэг хэрэгсэл	38.0	40.9	46.3
Цахилгаан эрчим хүч	3.6	4.7	1.5
ҮХ элэгдэл	114.0	105.3	106.3
Цалин	159.5	182.9	226.0
ЭМНДШ	23.9	28.3	33.0
Хөдөлмөр хамгаалал	9.3	7.2	17.3
Дулаан уур ус	1.8	2.6	8.6
Бусдаар гүйцэтгүүлэх хөлс	112.0	41.6	247.8
Томилолт хээрийн нэмэгдэл	32.7	15.7	24.7
ТТАМА-сны төлбөр	1.8	1.8	1.9
Газрын төлбөр	0.3	0.5	0.6
ҮХХ-н татвар	4.5	2.8	2.9
Сургалт зар сурталчилгаа	0.9	1.1	1.6
Зээлийн хүү			15.0
Бусад	9.2	1.8	1.8
ДҮН	766.0	667.2	1110.1

Алба хаагчдын цалин хөлсийг хийснээр, цаг зэргийн цалингаар тооцон олгодог бөгөөд 2021 оноос салбарт олон жил ажилласны нэмэгдлийг олгож эхэлсэн байна.

Үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой төлөвлөгдөөгүй зардлуудыг санхүүжүүлж, үр ашиггүй зардлыг хяналтгүйгээр гаргасан байна. Үүнд:

- ✓ 2-р гарын үсэг буюу нягтлан бодогчийн гарын үсэггүйгээр гүйлгээ хийсэн, 87.4 сая
- ✓ Кассын зарцуулалт анхан шатны баримтгүй, тухайн ажил гүйлгээ бодитой гарсан эсэх нь тодорхой бус 146.6 сая
- ✓ АТГ-ын шалгалтын мөрөөр хуульч гэрээгээр ажиллуулж, төлөвлөгдөөгүй зардал гаргасан 3.6 сая
- ✓ АТГ-ын шинжээчээр ажилласан аудитын байгууллагад үйлчилгээний хөлс төлж, төлөвлөөгүй зардал санхүүжүүлсэн 12.9 сая
- ✓ Интернет банкаар, холбогдох эрх бүхий алба хаагчдын гарын үсэг тэмдэггүй гүйлгээ хийсэн 70.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Хөрөнгө оруулалтын зардал: Тухайн жилийн хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөхдөө үйл ажиллагаандаа нэн шаардлагатай байгаа хөрөнгийг худалдах авахаар тусгажээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө:

Хөрөнгийн нэр	2019	2020	2021
Бага оврын өргөгч кран	20.00		
Зөөврийн компьютер	1.80		
Асфальтан замын ан, цавын нөхөөсний төхөөрөмж		19.80	
Бензин хөдөлгүүртэй бетон зуурагч 0.3 м3		3.20	
л200 авто машины засвар		14.50	
Үйлчилгээний машин /navara/		9.00	
Үйлчилгээний машин			20.00
Далангийн индүү			60.00
Зөөврийн клонк			35.00
Маяти кран			45.00
Замын тэмдэглэгээний машин			20.00
Зөөврийн компьютер			5.00
ДҮН	21.80	46.50	185.00

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг судлан үзэхэд төлөвлөсөн хөрөнгийн оронд өөр нэр төрлийн хөрөнгө бэлтгэсэн, төлөвлөгөөнд тусгасан зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчлүүд байна.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах хөрөнгүүдийг бэлтгэсэн байна.

- ✓ Трансметр суурилуулсан бөгөөд гэрээ байгуулаагүй 9.0 сая
- ✓ Гүйцэтгэх удирдлага болон эдийн засагч нарт компьютер худалдан авсан 5.3 сая
- ✓ Төлөвлөгөөнд тусгасан зардлыг хэтрүүлэн зарцуулсан 16.4 сая төгрөг зэрэг зөрчил байна.

Эдгээр бэлтгэсэн хөрөнгүүд нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд ач холбогдол багатай байна гэж үзлээ.

Мөн зам тээврийн хөгжлийн яамнаас хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 152.3 сая төгрөгийн авто гридерийг данс бүртгэлд тусган ажилласан байна.

БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Хөндлөнгийн хяналтууд тодорхой хэмжээнд хийгдсэн байна.

ТӨХК-ний хяналтыг үйл ажиллагаа, санхүү, дотоод хяналтын хүрээнд судлан үзлээ.

***Үйл ажиллагааны хяналт:** Тус байгууллагын үйл ажиллагаанд дараах байгууллагууд хяналт тавьж ажилласан байна.*

- ✓ Зам тээврийн хөгжлийн яамнаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг жил бүр тогтмол хийсэн байна.

Хяналт шалгалтад дараах зүйлсийг хамруулжээ.

- Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын ашиглалтын бэлэн байдал, засвар арчлалтын байдал,
- УТХО-аар хэрэгжиж буй хатуу хучилттай авто замд үзлэг шалгалт хийх, авто замын бэлэн байдал,
- Гадаадын зээл тусламж, төр хувийн хэвшил, концессын гэрээ, эрх шилжсэн, шинээр болон он дамжин баригдаж буй авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил
- Шуурхай хэсгүүдийн ажилтай танилцах, төрийн өмчийн эд хөрөнгөнд хэрхэн зүй зохистой хандаж байгаа,
- Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт, өргөдөл гомдол шийдвэрлэлт,
- Авто замын тухай хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартын хэрэгжилт
- Замд байрлах төлбөр авах цэгийн үйл ажиллагаа, тэнхлэгийн даацад хяналт шалгалт хийсэн байна.

Дээрх шалгалтуудаар авто замд тогтмол үзлэг хийдэггүй, авто замын засвар арчлалтын ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэггүй, засвар арчлалтын ажлын төсөв болон график төлөвлөгөө гараагүй, хариуцсан замд үүссэн нийт эвдрэлийн тоо хэмжээ, хийгдэх засвар арчлалтын ажлын төсөвт өртөг багтаагүй үлдсэн ажлын тоо хэмжээ гаргаж, хэмжилтийг фото зургаар баримтжуулан үзлэгийн хуудас үйлдэж, журналаа баталгаажуулаагүй гэсэн зөрчил нийтлэг илэрсэн байна. Энэ нь тухайн ТӨХК нь ашигтай ажиллахын тулд ажлыг дутуу, чанаргүй хийсэн байх эрсдэл ажиглагдлаа.

- ✓ Аймгийн МХГ-аас жил бүр замын ашиглалт, арчлалтын байдал, хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилт, зам барилга байгууламжийн ажлын чанар шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоож илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гарч болох эрсдэлийг тодорхойлж урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

- ✓ Цагдаагийн газар- Замын аюулгүй байдалд хяналт хийж зам тээврийн осол гарах нөхцөл байдал үүссэн асуудлыг мэдэгдэж, засвар үйлчилгээ хийх мэдэгдлийг хүргүүлэн ажилладаг байна.

Санхүүгийн үйл ажиллагааны хяналт: Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дараах байгууллагууд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

- ✓ ТӨБЗГ-аас 2019 онд тус байгууллагын 2016, 2017 онуудын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримт шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөдөлмөр хамгааллын болон хангамжийн материал худалдан авсан 68.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- ✓ ТӨБЗГ-аас 2020 онд 33 хуулийн этгээдийн санхүү аж ахуй, удирдлагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хийсэн байна. хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг алдаа зөрчилтэй холбоотой 13 төрлийн алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх албан даалгавар ирүүлсэн байна.
- ✓ Төрийн аудит байгууллага жил бүр санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэсэн байна. 2019, 2020 онд зөрчилгүй, 2021 онд Сөрөг санал дүгнэлт өгсөн байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааг алдагдалтай тайлагнаж, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж өглөг үүсгэсэн, авлагыг дутуу бүртгэсэн зэрэг 584.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнтэй холбоотой байна.

Холбогдох эрх бүхий байгууллагуудаас удаа дараа зөвлөмж, албан шаардлага, албан даалгавар, чиглэл өгсөн байхад тухайн байгууллагын алдаа дутагдал арилаагүй байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Компанийн засаглалын кодексийн үзүүлэлтэд компани нь дотоод хяналтын тогтолцоог бий болгосон байна, ТӨХК-ний дүрэмд компанийн хяналтын тогтолцоо нь өмчийн хяналт, дотоод хяналт, хөндлөнгийн аудит гэсэн бүтэцтэй байна, өмчлөгчийн хяналтын ТУЗ-н дэргэдэх аудитын хороо, дотоод хяналтыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ гэж тусгасан байна.

ТУЗ-ийн дэргэд аудитын хороог 3 гишүүнтэй байгуулсан байна. Тус хороо нь хяналт шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллаагүй байна. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа хангалтгүй байна гэж үзлээ.

Мөн гүйцэтгэх захирлын дэргэд хяналтын нэгж байгуулаагүйгээс тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа ямар ч хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдаж байна. Тухайлбал:

- АТГ-ын шинжээчээр ажиллаж буй Улаанбаатар хот дахь Мэдээлэл аудит ХХК-аар 2020 болон 2021 оны 06 сарын 30 -ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар хөрөнгийн зориулалт бус үр ашиггүй зарцуулсан, хувь иргэдээс авсан зээлийг зарцуулалт, ТУЗ-ийн шийдвэргүй цалин нэмэгдүүлсэн, ашигтай гарахын тулд зарцуулсан материалын зардлыг үлдэгдлээр тайлагнасан, зардлыг зөв ангилж бүртгээгүй зэрэгтэй холбоотой 201.1 сая төгрөгийн алдаа илрүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн байна. Үүнээс 2020 онд 156.0 сая, 2021 оны эхний хагас жилд 45.1 сая төгрөгийн зөрчил хамаарч байгаагаас 162.2 сая төгрөгийг нөхөн төлүүлэх зорилгоор авлагаар тусгуулж, 38.9 сая төгрөгийн зөрчлийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд залруулсан байна.

- Аудитаар 378.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 163.1 сая

төгрөгийн зөрчилд албан шаардлага, 215.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.3 Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах ажил хангалтгүй байна.

ЗТХЯ, ТӨБЗГ болон бусад харилцаг байгууллагатай тухайн газруудын цахим сайтад дамжуулан мэдээллийг солилцож байна. Тухайлбал: ЗТХЯ-ны зам засвар арчлалтын цахим хуудсанд мэдээллийг тухай бүр байршуулж байна. ТӨБЗГ-ын цахим хуудсанд тавигдсан мэдээллийг тухай бүр авч, үйл ажиллагаагаа явуулж байна.

ТӨХК нь жил бүр санхүүгийн тайлангаа СТОУС болон холбогдох хууль журмын хүрээнд гарган хөндлөнгийн аудит хийлгүүлсэн байна. Энэхүү хөндлөнгийн аудитын дүгнэлтийг ТУЗ-д танилцуулан ажиллаж хэвшжээ.

Шилэн дансны цахим мэдээллийг Сангийн яамнаас тухай бүр хянаж, заавар зөвлөгөө өгч ажилласан байна. Завхан-АЗЗА ТӨХК нь шилэн дансны мэдээллийг байршуулан ажилласан байна.

“Завхан-АЗЗА” ТӨХК нь байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах талаар ажил хийгээгүй байна. Мөн цахим хуудас ажиллуулдаггүй бөгөөд фэйсбүүк хуудас нээсэн хэдий ч тогтвортой ажиллуулаагүй байна.

ДҮГНЭЛТ:

1. Тус компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй, үндсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.
2. Компанийн эдийн засгийн зорилтод түвшний үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй байна.
3. Үйл ажиллагаагаа өргөжүүлэн нэмэлт орлого олох талаар ажил зохион байгуулаагүй байна.
4. Компанийн үйл ажиллагаанд үр ашгийн шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.
5. Техник тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө, мэргэжилтэй боловсон хүчний нөөц хангалтгүй байна.
6. Мөнгөн хөрөнгийн хомсдолд орсны улмаас хувь иргэдээс зээл авсан томоохон зөрчил илэрсэн.
7. Компанийн удирдлагаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
8. Компанийн үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна.

ҮАГ-ЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ:

1. Орон нутаг дахь төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахын тулд ТУЗ-д орон нутгийн төлөөллийг оруулах замаар орон нутгийн зүгээс оролцох, хяналт тавих хууль эрх зүйн орчин бүрдүүлэх
2. Сангийн сайдын 2006 оны 292 тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын хүрээнд балансын урамшуулал олгож байгаа нь үндэслэлгүй байна. Тус журам хүчин төгөлдөр эсэх нь тодорхой бус, хүчингүй болсон хуулийн үйлчлэлтэй байна.
3. ТӨХК-ний хүрээнд интернэт банкаар гүйлгээ хийх эрх олгосон, гарын үсэг, байгууллагын тамга тэмдгээр баталгаажуулаагүй баримтаар гүйлгээ хийсэн зөрчлүүд байна. Иймд арилжааны банкнуудад дээрх зөрчлийг үүсэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх талаар хамтран ажиллах зөвлөмж хүргүүлэх

ЗӨВЛӨМЖ

“ЗАВХАН-АЗЗА” ТӨХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТТУЛГА-Д

Төрийн болон орон нутгийн өмчим, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар өгсөн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Байгууллагын эдийн засгийн зорилтод түвшний үзүүлэлтийг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллах
2. Гүйцэтгэх удирдлагын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулан, ажиллах журмыг боловсруулан мөрдүүлэх
3. Төлөвлөөгүй хөрөнгө оруулалт, зардлыг санхүүжүүлэхдээ ТУЗ-д танилцуулж шийдвэр гаргуулж байх
4. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээлэх, таниулах сувгийг бий болгох
5. Аудитаар өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА